



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 сарын 05 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

МАЛЧИН ӨРХИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилго, зорилт

1.1. Энэ хуулийн зорилго нь малчин, мал, бэлчээрийн харилцан шүтэлцээнд тулгуурлан бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт соёлыг хадгалах, малчдын хамтын менежментийг төлөвшүүлж, нийтлэг эрх ашгийг хамгаалах, байгалийн нөөц, бэлчээрийг даацад нь тохируулан зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын чанар, ашиг шимийг сайжруулах замаар малчдын амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.2. Энэ хуулийн зорилт нь малчин өрхийн холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын хууль тогтоомж

2.1. Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль[4], Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээгээр ашиглуулах, гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр дэх байгалийн нөөцийг хууль тогтоомжид заасны дагуу ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд малчдын оролцоог хангах, малчин өрхийн холбооны тогтолцоог өөрөө удирдах ёсны зарчимд нийцүүлэн зохион байгуулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.2. Малчин өрхийн эрх зүйн байдалтай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

3.3. Бэлчээрийг гэрээгээр ашиглахтай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Газрын тухай хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасныг;

4.1.2. "малчин өрх" гэж жилийн дөрвөн улиралд мал аж ахуй эрхэлж, түүний ашиг шимээр үндсэн орлогоо олдог өрхийг;

4.1.3. "малчин өрхийн анхдагч холбоо" гэж сайн дурын үндсэн дээр, малчин өрхийн нийтлэг эрх ашгийн төлөө өөрөө удирдах зарчимд үндэслэн энэ хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээдийг;

4.1.4. "байгалийн нөөц" гэж гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр дэх байгалийн ургамал, уст цэг, ан амьтан зэргийг.

5 дугаар зүйл. Малчин өрхийн холбооны эрх зүйн байдал, үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1. Малчин өрхийн холбоо нь гишүүддээ үйлчилдэг, ашгийн төлөө бус хуулийн этгээд байна. Малчин өрхийн холбоо нь малчин өрхийн анхдагч холбоо, сумын, аймгийн, нэгдсэн холбооны зохион байгуулалттай байна.

5.2. Төрийн зарим чиг үүргийг малчин өрхийн холбоогоор хуульд заасны дагуу, эсхүл гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

5.3. Малчин өрхийн холбоо үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

5.3.1. гишүүдийн оролцоо, үүрэг, хариуцлагын тэгш, шударга байдлыг хангах;

5.3.2. ил тод, нээлттэй байх;

5.3.3. улс төрөөс ангид байх.

6 дугаар зүйл. Малчин өрхийн холбооны дүрэм

6.1. Малчин өрхийн холбооны дүрэм /цаашид "дүрэм" гэх/-д дараах асуудлыг тусгана:

- 6.1.1. холбооны оноосон нэр;
 - 6.1.2. холбооны бүтэц, зохион байгуулалт;
 - 6.1.3. холбооны санхүүжилт, түүнийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах;
 - 6.1.4. гишүүний эрх, үүрэг;
 - 6.1.5. гишүүнээр элсүүлэх, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, гишүүнээс гарах, гаргах үндэслэл, журам;
 - 6.1.6. холбооноос хоршоо, нөхөрлөл, компани зэрэг бусад этгээдтэй харилцах зарчим, журам;
 - 6.1.7. холбоог өөрчлөн байгуулах, татан буулгах;
 - 6.1.8. дүрэм зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага;
 - 6.1.9. анхдагч холбооны бүх гишүүдийн хурал /цаашид "бүх гишүүдийн хурал" гэх/-тай холбогдсон энэ хуульд зааснаас бусад асуудал;
 - 6.1.10. энэ хуульд заасан бусад.
- 6.2. Холбооны дүрэм, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МАЛЧИН ӨРХИЙН АНХДАГЧ ХОЛБОО, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

7 дугаар зүйл. Малчин өрхийн анхдагч холбоог үүсгэн байгуулах, улсын бүртгэлд бүртгүүлэх

- 7.1. Тухайн сумын нутаг дэвсгэр дэх зэргэлдээ малчин өрхүүд бэлчээрийг зохистой ашиглаж, амьжиргаагаа дээшлүүлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдэж, малчин өрхийн анхдагч холбоо /цаашид "анхдагч холбоо" гэх/-г үүсгэн байгуулж болно. Анхдагч холбоо нь газар нутгийн онцлог, бэлчээрийн нөхцөл байдлаас хамаарч 10-аас доошгүй малчин өрхийн гишүүнчлэлтэй байна.
- 7.2. Анхдагч холбоог үүсгэн байгуулах хурлыг энэ хуулийн 7.1-д заасан малчин өрхийн төлөөлөл зохион байгуулж, уг хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:
- 7.2.1. анхдагч холбоо үүсгэн байгуулах тухай шийдвэр гаргах;
 - 7.2.2. анхдагч холбооны дүрмийг батлах;
 - 7.2.3. анхдагч холбооны ахлагч, тэргүүлэгчдийг сонгох.
- 7.3. Анхдагч холбоог үүсгэн байгуулах шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

8 дугаар зүйл. Анхдагч холбоо, түүний үйл ажиллагаа

- 8.1. Анхдагч холбоо нь хуульд заасны дагуу дараах үйл ажиллагаанд гишүүдийнхээ эрх, ашиг сонирхлыг илэрхийлж, зохион байгуулж оролцоно:
- 8.1.1. малчин өрхийн гишүүнийг боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах;
 - 8.1.2. гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;
 - 8.1.3. малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах;
 - 8.1.4. мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулахад дэмжлэг үзүүлэх.
- 8.2. Анхдагч холбоо гишүүдийн бүртгэлийг хөтөлнө.
- 8.3. Анхдагч холбоо нь гишүүдэд төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэнэ.
- 8.4. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн цаг үеийн шинжтэй, нэмэлт ажиллах хүч шаардагдах ажлын үед анхдагч холбооны гишүүд харилцан тусалж, хамтран ажиллана.
- 8.5. Анхдагч холбооны малчин өрхийн гишүүн холбогдох хуульд заасны дагуу нөхөрлөл, хоршоо, компанийн үүсгэн байгуулагч, гишүүн, хувьцаа эзэмшигч байж болно.

9 дүгээр зүйл. Боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах

- 9.1. Анхдагч холбоо нь малчин өрхийн гишүүдийг боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ:
- 9.1.1. нарийн мэргэжлийн болон эрүүл мэндийн бусад тусламж, үйлчилгээ авах хүсэлтийг сумын эрүүл мэндийн төвд уламжилж, хамтран ажиллах;
 - 9.1.2. албан болон албан бус сургалтад хамруулах;

9.1.3.холбогдох байгууллагаас зохион байгуулах мал аж ахуйн үйлдвэрлэлийн арга, технологи, бизнесийн үйл ажиллагааны талаар мэдлэг түгээх, малчдын ур чадварыг сайжруулахад чиглэсэн мэргэжил, арга зүйн зөвлөн нэвтрүүлэх үйлчилгээнд гишүүдийг хамруулах;

9.1.4.нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулах, холбогдох мэдээллээр хангах.

9.2.Энэ хуулийн 9.1.1, 9.1.2-т заасан харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

10 дугаар зүйл.Гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх

10.1.Анхдагч холбоо нь гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр дараах үйл ажиллагаанд Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу гишүүдийг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ:

10.1.1.байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, хөрсний үржил шимийг сайжруулах ажлыг зохион байгуулах;

10.1.2.гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг даацад нь нийцүүлэн улирлын хуваарьтай ашиглах, сэлгэх, өнжөөх, бэлчээрийн төлөв байдал, голлох зүйл ургамлын эзлэх хувийг гэрээ байгуулах үеийн тогтоосон суурь түвшнээс бууруулахгүй байх;

10.1.3.гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглахад хяналт тавих;

10.1.4.гамшиг, аюулт үзэгдлийн улмаас гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг Газрын тухай хуулийн 21.4.5, 21.4.6-д заасны дагуу ашиглуулахад хяналт тавих;

10.1.5.тухайн жилийн бэлчээрийн гарц, байгаль, цаг уурын урьдчилсан төлөв байдлыг харгалзан өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэх;

10.1.6.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.5.1, 7.5.2, 7.5.3-т заасан шаардлагыг хангасан, халдварт өвчний шинж тэмдэг илрээгүй мал оруулах, дамжин өнгөрүүлэхэд хяналт тавих;

10.1.7.гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрт хорио цээртэй өвчин гарах, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал тархахаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд холбогдох арга хэмжээг авах;

10.1.8.бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, хөв цөөрөм байгуулах;

10.1.9.мал, амьтны сэг зэм устгал, орчны халдваргүйтгэлийн арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

10.1.10.газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлангийн талбайг ашиглах;

10.1.11.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эргүүл хийх, баримтжуулах, таслан зогсоох, мэдээлэх зэргээр эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах;

10.1.12.тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх байгаль хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөөний төсөлд санал өгөх;

10.1.13.байгалийн нөөцийг хамгаалахтай холбогдсон хуульд заасан бусад үүрэг.

10.2.Газрын тухай хуулийн 52.7-д заасан газарт тэжээлийн ургамал тариалж болно.

10.3.Гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрт таримал ургамал тарихыг хориглоно.

10.4.Гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрээс бусад газарт тэжээлийн болон бусад таримал ургамал тариалах асуудлыг Тариалангийн тухай хуулиар^[9] зохицуулна.

10.5.Анхдагч холбооны гишүүн бус малчин өрх анхдагч холбооны гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг ашиглах тохиолдолд нийтийн эрх ашгийг хүндэтгэн түүнийг зохистой ашиглаж, хамгаална.

11 дүгээр зүйл.Малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах

11.1.Анхдагч холбоо нь малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр дараах үйл ажиллагаанд гишүүдийг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ:

11.1.1.малын чанар, ашиг шимийг сайжруулах, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

11.1.2.тухайн бүс нутгийн онцлогт дасан зохицсон, баталгаажсан үүлдэр, омгийн малыг үржилд ашиглах, үржлийн мал бойжуулах, мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг технологит хугацаанд хэрэгжүүлэх;

11.1.3.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, гарал үүслийг бүртгэх;

11.1.4.мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчинтэй тэмцэх арга хэмжээнд малаа товлосон хугацаанд бүрэн хамруулах, эрүүл мэндийн бүртгэлийн дэвтрийг тогтмол хөтлөх;

11.1.5.малын индексжүүлсэн даатгалд хамруулах.

12 дугаар зүйл.Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулахад дэмжлэг үзүүлэх

12.1.Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулах чиглэлээр дараах үйл ажиллагаанд гишүүдийг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ:

12.1.1.малын гаралтай түүхий эдийг нэг цэгт төвлөрүүлэн анхан шатны ангилалт, тордолт хийх, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх;

12.1.2.стандартын шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой мал, малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, борлуулах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ **АНХДАГЧ ХОЛБООНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ**

13 дугаар зүйл. Анхдагч холбооны удирдлага, зохион байгуулалт

13.1. Анхдагч холбооны эрх барих байгууллага нь бүх гишүүдийн хурал, түүний чөлөөт цагт тэргүүлэгчид байна.

13.2. Анхдагч холбоо нь таваас дээшгүй тэргүүлэгчтэй байх бөгөөд тэдгээрийг 2 жил тутам бүх гишүүдийн хурлаас сонгоно.

13.3. Анхдагч холбооны бүх гишүүдийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах ахлагчтай байна.

13.4. Ахлагч нь сумын малчин өрхийн холбоонд болон бусад этгээдийн өмнө анхдагч холбоог төлөөлнө.

13.5. Анхдагч холбооны тэргүүлэгчдийн шийдвэрээр ахлагчийн эрх, үүргийг аль нэг тэргүүлэгчид түр шилжүүлж болно.

13.6. Анхдагч холбооны тэргүүлэгчдийн энэ хуульд зааснаас бусад эрх, үүргийг тухайн холбооны онцлогт тохируулан дүрмээр тодорхойлно.

14 дүгээр зүйл. Бүх гишүүдийн хурлын бүрэн эрх

14.1. Бүх гишүүдийн хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1. дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

14.1.2. ахлагч болон тэргүүлэгчдийг сонгох, чөлөөлөх, огцруулах;

14.1.3. гишүүний хураамжийн хэмжээг тогтоох;

14.1.4. анхдагч холбооны жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх;

14.1.5. бэлчээрийг гэрээгээр ашиглах хүсэлтийг сумын Засаг даргад гаргах, бэлчээрийг сэлгэх, нөхөн сэргээх хуваарийг батлах;

14.1.6. гишүүнээр элсүүлэх, гишүүнээс гаргах, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, сэргээх тухай шийдвэр гаргах;

14.1.7. анхдагч холбоог өөрчлөн байгуулах, татан буулгах;

14.1.8. хууль болон дүрэмд заасан бусад бүрэн эрх.

14.2. Гэрээгээр ашиглаж байгаагаас бусад бэлчээрийг ашиглах, отор нүүдэл хийх асуудлыг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн хүсэлтээ сумын Засаг даргад гаргана.

14.3. Шинээр өрх тусгаарласан болон шилжиж ирсэн малчин өрхийг анхдагч холбоонд элсүүлэх шийдвэрийг бэлчээрийн даацад тохируулан сумын Засаг даргын саналыг үндэслэн бүх гишүүдийн хурал шийдвэрлэнэ.

15 дугаар зүйл. Анхдагч холбооны гишүүнчлэл дуусгавар болох

15.1. Анхдагч холбооны гишүүнчлэл дараах үндэслэлээр дуусгавар болно:

15.1.1. өөрийн хүсэлтээр анхдагч холбооны гишүүнээс гарсан;

15.1.2. анхдагч холбооны үйл ажиллагаа дуусгавар болсон;

15.1.3. анхдагч холбооны гишүүнчлэлээс гаргасан.

15.2. Гишүүнчлэл нь дуусгавар болсон малчин өрхийн анхдагч холбоонд төлсөн гишүүний хураамжийг буцаан олгохгүй.

15.3. Дүрэмд өөрөөр заагаагүй бол малчин өрх анхдагч холбооны гишүүнчлэлээс гарахдаа энэ тухайгаа бичгээр мэдэгдэнэ.

15.4. Анхдагч холбооны гишүүнчлэлээс гаргах асуудлыг шийдвэрлэх хуралд тухайн гишүүн өрхийн төлөөллийг оролцуулна. Түүний эзгүйд, өөрийнх нь зөвшөөрснөөр уг шийдвэрийг гаргаж болно.

15.5. Гишүүнчлэлээс гаргасан тухай шийдвэрийг тухайн этгээдэд даруй бичгээр мэдэгдэнэ.

15.6. Гишүүнчлэлээс гаргасантай холбоотой гомдлыг хянан шийдвэрлэх журмыг дүрэмд зааж болно.

16 дугаар зүйл. Бүх гишүүдийн хурал

16.1. Анхдагч холбооны нийт гишүүдийн олонх оролцсоноор бүх гишүүдийн хурлыг хүчин төгөлдөр болсонд тооцно.

16.2. Бүх гишүүдийн хурлын тов, хэлэлцэх асуудлыг ахлагчийн саналыг үндэслэн тэргүүлэгчид тогтоох бөгөөд дүрэмд өөрөөр заагаагүй бол бүх гишүүдийн хурлын зарыг хурал болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө гишүүдэд хүргэнэ.

- 16.3.Анхдагч холбооны нийт гишүүдийн гуравны нэгээс дээш хувийн саналаар бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулж болно.
- 16.4.Бүх гишүүдийн хуралд оролцсон гишүүн тус бүр нэг саналын эрхтэй байна.
- 16.5.Бүх гишүүдийн хуралд оролцох малчин өрхийн төлөөлөл нь эрх зүйн бүрэн чадамжтай иргэн байна.
- 16.6.Бүх гишүүдийн хурлын шийдвэр хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар хүчин төгөлдөр болно.
- 16.7.Бүх гишүүдийн хурлын тэмдэглэлийг хөтлөх бөгөөд тэмдэглэлд хурал даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

17 дугаар зүйл.Ахлагч, түүний эрх, үүрэг

- 17.1.Ахлагчийг гишүүд дундаасаа нэр дэвшүүлж, бүх гишүүдийн хурлаас 2 жилийн хугацаатай сонгоно.
- 17.2.Ахлагч дараах эрхтэй:
 - 17.2.1.тэргүүлэгчдээс олгосон бүрэн эрхийн хүрээнд анхдагч холбоог төлөөлөн гэрээ, хэлцэл хийх;
 - 17.2.2.дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд анхдагч холбооны эд хөрөнгийг захиран зарцуулах шийдвэр гаргах;
 - 17.2.3.дүрэмд заасан бусад.
- 17.3.Ахлагч дараах үүрэгтэй:
 - 17.3.1.анхдагч холбоо болон тэргүүлэгчдийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
 - 17.3.2.анхдагч холбооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жил бүр хуульд заасан журмын дагуу гаргаж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;
 - 17.3.3.анхдагч холбооны гишүүдийн бүртгэлийг хөтлөх ажлыг зохион байгуулах;
 - 17.3.4.нягтлан бодох бүртгэлийг хуульд заасан журмын дагуу хөтлөх ажлыг зохион байгуулах;
 - 17.3.5.дүрэмд заасан бусад.
- 17.4.Ахлагчид урамшуулал олгож болох бөгөөд урамшууллын хэмжээг бүх гишүүдийн хурлаас тогтооно.

18 дугаар зүйл.Анхдагч холбооны санхүүжилт

- 18.1.Анхдагч холбооны санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:
 - 18.1.1.гишүүний хураамж;
 - 18.1.2.хууль тогтоомжийн дагуу олгосон санхүүжилт;
 - 18.1.3.энэ хуульд заасан үйл ажиллагаа эрхэлж олсон орлого;
 - 18.1.4.гадаад, дотоодын хуулийн этгээд, хувь хүний хандив, тусламж;
 - 18.1.5.хууль тогтоомж, дүрэмд заасан бусад эх үүсвэр.
- 18.2.Анхдагч холбооны хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулна:
 - 18.2.1.энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагаа;
 - 18.2.2.дүрэмд заасан бусад.
- 18.3.Малчин өрхийн анхдагч холбоо нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх явцад олсон орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгыг хэрэгжүүлэхэд зарцуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СУМ, АЙМГИЙН МАЛЧИН ӨРХИЙН ХОЛБОО, МАЛЧИН ӨРХИЙН НЭГДСЭН ХОЛБОО, ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

19 дүгээр зүйл.Сумын малчин өрхийн холбоо, түүний зохион байгуулалт

- 19.1.Анхдагч холбоод нэгдэж, сумын малчин өрхийн холбоог байгуулна.
- 19.2.Сумын малчин өрхийн холбоо /цаашид "сумын холбоо" гэх/ нь гишүүн анхдагч холбоо бүрийн ахлагч нараас бүрдэнэ.
- 19.3.Сумын холбоог үүсгэн байгуулах хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:
 - 19.3.1.холбоо үүсгэн байгуулах тухай шийдвэр гаргах;
 - 19.3.2.холбооны дүрмийг батлах;
 - 19.3.3.холбооны зохион байгуулалтыг тодорхойлж, удирдлагыг сонгох.
- 19.4.Сумын холбоог үүсгэн байгуулах шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

- 19.5.Сумын холбооны хурлыг жилд нэгээс доошгүй удаа хуралдуулна.
- 19.6.Сумын холбооны даргыг гишүүд дундаасаа нэр дэвшүүлж, 2 жилийн хугацаатай сонгоно.
- 19.7.Сумын холбооны удирдлага, зохион байгуулалт, санхүүжилттэй холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг дүрмээр тогтооно.
- 19.8.Сумын холбоо үйл ажиллагаагаа явуулахад сумын Засаг дарга дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

20 дугаар зүйл.Сумын холбооны үйл ажиллагаа

20.1.Сумын холбоо дараах үйл ажиллагааг явуулна:

- 20.1.1.гишүүдийн үйл ажиллагааг дэмжих, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах;
- 20.1.2.энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааны хүрээнд сумын түвшинд баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, энэ талаарх саналаа сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;
- 20.1.3.стандартын шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой мал, малын гаралтай түүхий эд бэлтгэх, борлуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- 20.1.4.сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний төсөлд санал гаргах;
- 20.1.5.сумын төсвийн төсөл, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх мал аж ахуй, бэлчээр, байгаль хамгаалах арга хэмжээний талаар санал гаргах;
- 20.1.6.гишүүдийн саналд тулгуурлан гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
- 20.1.7.энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааны хүрээнд гишүүд, бусад аймаг, сумын холбооны сайн туршлага, үйлдвэрлэлийн шинэ арга технологийг зөвлөн нэвтрүүлэх үйлчилгээг зохион байгуулах.

21 дүгээр зүйл.Аймгийн малчин өрхийн холбоо, түүний зохион байгуулалт

- 21.1.Сумын холбоод нэгдэж, аймгийн малчин өрхийн холбоог байгуулна.
- 21.2.Аймгийн малчин өрхийн холбоо /цаашид "аймгийн холбоо" гэх/ нь сумын холбоо бүрээс сонгогдсон хоёр гишүүний төлөөллөөс бүрдэнэ.
- 21.3.Аймгийн холбоог үүсгэн байгуулах хурлаар энэ хуулийн 19.3.1, 19.3.2, 19.3.3-т заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 21.4.Аймгийн холбоог үүсгэн байгуулах шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.
- 21.5.Аймгийн холбооны даргыг гишүүд дундаасаа нэр дэвшүүлж, аймгийн холбооны хурлаас 3 жилийн хугацаатай сонгоно.
- 21.6.Аймгийн холбооны удирдлага, зохион байгуулалт, санхүүжилттэй холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг аймгийн холбооны дүрмээр тогтооно.

22 дугаар зүйл.Аймгийн холбооны үйл ажиллагаа

22.1.Аймгийн холбоо дараах үйл ажиллагааг явуулна:

- 22.1.1.сумын холбооны үйл ажиллагааг дэмжих, гишүүдийн хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах;
- 22.1.2.энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааны хүрээнд аймгийн түвшинд баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;
- 22.1.3.аймгийн төсвийн төсөл, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх мал аж ахуй, бэлчээр, байгаль хамгаалах арга хэмжээний талаар санал гаргах;
- 22.1.4.аймгийн хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт санал гаргах.

23 дугаар зүйл.Малчин өрхийн нэгдсэн холбоо, түүний зохион байгуулалт

- 23.1.Аймгийн малчин өрхийн холбоод нэгдэж, улсын хэмжээнд малчин өрхийн нэгдсэн холбоог /цаашид "нэгдсэн холбоо" гэх/ байгуулна.
- 23.2.Нэгдсэн холбоонд аймгийн холбоодыг аймгийн холбооны дарга нар төлөөлнө.
- 23.3.Нэгдсэн холбоог үүсгэн байгуулах хурлаар энэ хуулийн 19.3.1, 19.3.2, 19.3.3-т заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 23.4.Нэгдсэн холбоог үүсгэн байгуулах шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.
- 23.5.Нэгдсэн холбооны тэргүүнийг гишүүд дундаасаа нэр дэвшүүлж, 4 жилийн хугацаатай сонгоно.
- 23.6.Нэгдсэн холбооны гишүүдийн хурлыг жилд нэгээс доошгүй удаа хуралдуулна.
- 23.7.Нэгдсэн холбооны удирдлага, зохион байгуулалт, санхүүжилттэй холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг

дүрмээр тогтооно.

24 дүгээр зүйл.Нэгдсэн холбооны үйл ажиллагаа

24.1.Нэгдсэн холбоо дараах үйл ажиллагааг явуулна:

- 24.1.1.малчин, мал аж ахуй, байгалийн нөөцийн менежментийн чиглэлийн хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг боловсронгуй болгох талаар гишүүдийн саналыг нэгтгэн боловсруулж, хууль тогтоомж, бодлогын баримт бичигт тусгуулах арга хэмжээ авах;
- 24.1.2.нүүдлийн мал аж ахуйн уламжлалт өв соёл, заншил, мал маллах арга ухааныг сурталчлах;
- 24.1.3.бүс нутгийн болон олон улсын хэмжээнд ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтран ажиллах;
- 24.1.4.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх нэгдсэн сүлжээ бий болгох талаар эрх бүхий байгууллагад санал гаргах;
- 24.1.5.нэгдсэн холбооны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн хүрээнд бүрдүүлэх;
- 24.1.6.холбооны мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх.

25 дугаар зүйл.Малчин өрхийн холбоонд хориглох үйл ажиллагаа

25.1.Малчин өрхийн холбоо нь доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

- 25.1.1.улс төрийн нам, улс төрийн намын байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэх;
- 25.1.2.шашин номлох, ухуулан дэлгэрүүлэх зэрэг шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах;
- 25.1.3.үндсэн зорилго, үйл ажиллагаагаа өөрчилж, ашгийн төлөө ажиллах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнөөс хөрөнгийн баталгаа гаргах.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД

26 дугаар зүйл.Малчин өрхийн холбооноос төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах

- 26.1.Малчин өрхийн холбоо нь зорилгодоо хамаарах аливаа асуудлаар зохих шатны төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах эрхтэй.
- 26.2.Аймгийн болон сумын холбоо нь орон нутгийн зохих шатны удирдлагад холбооны үйл ажиллагааны тайланг танилцуулна.

27 дугаар зүйл.Малчин өрхийн холбоонд төрөөс үзүүлэх дэмжлэг

- 27.1.Гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон үед анхдагч холбоонд төрөөс дэмжлэг үзүүлж болно.
- 27.2.Мал аж ахуйн үйлдвэрлэлд зохистой дадал нэвтрүүлэхэд залуу малчдад зориулсан сургалтын тогтолцоог бий болгох, хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

28 дугаар зүйл.Холбоог өөрчлөх, татан буулгах

- 28.1.Холбоог өөрчлөх, татан буулгах асуудлыг Иргэний хуульд нийцүүлэн баталсан дүрмээр зохицуулна.

29 дүгээр зүйл.Холбооны тайлан

- 29.1.Холбоо нь хууль, дүрэмд заасны дагуу үйл ажиллагаа, санхүүжилт, түүний зарцуулалтыг гишүүддээ тайлагнана.
- 29.2.Холбоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу татварын тайлан гаргаж, харьяа татварын албанд тайлагнана.
- 29.3.Холбоо албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаандаа Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасан албан хэрэг хөтлөлт болон байгууллагын архивт баримтлах журмыг мөрдөнө.

30 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох хугацаа

- 30.1.Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР